



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/301

Мандалговь

Бруцеллёзын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 –ын “а”, 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, аймгийн Засаг даргын 2016 – 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн А/127 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал сүргийг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд зохион байгуулахыг сум, багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай.

Хоёр. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах төлийн тоо, шаардагдах вакцины хуваарь, үйлчилгээний хөлсний тооцоог 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан зөвлөмжийг баримтлаж мэргэжлийн удирдлагаар ханган, хяналт тавин зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190877

08 сарын 28-ны өдрийн 301 дугаар захирамжийн 1-р хавсралт



БРУЦЕЛЛЭЗЫН ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ ТӨЛИЙН ТОО, ВАКЦИНЫ ТУН, ҮНЭ, АЖЛЫН ХӨЛСНИЙ ДҮН

№	Сумын нэр	2019 онд вакцинжуулалтад хамрагдах охин төл /гол/				Шардагдах вакцины хэмжээ		Вакцины үнэ /мян.төг/	Шингэлэгч /литр/	Шингэлэгч үнэ /мян.төг/	Үйлчилгээний хөлс			Нийт /мян.төг/
		Бүгд	Тугал	Хурга	Ишиг	br.abortus 19 омог /мян-тун/ 254100	br.Melitensis Rev-1 /мян-тун/ 150150				Тугал 200	Хурга, ишиг 150	Бүгд /мян төг/	
1	Дэлгэрцогт	37,300	300	19,000	18,000	0.3	37.0	5,631,780	37.6	109,491	60,000	5,550,000	5,610,000	11,351,271
2	Дэрэн	66,500	1,500	33,000	32,000	1.5	65.0	10,140,900	68.0	198,016	300,000	9,750,000	10,050,000	20,388,916
3	Говь-Угтаал	42,300	300	22,400	19,600	0.3	42.0	6,382,530	42.6	124,051	60,000	6,300,000	6,360,000	12,866,581
4	Баянжаргалан	30,900	900	17,500	12,500	0.9	30.0	4,733,190	31.8	92,602	180,000	4,500,000	4,680,000	9,505,792
5	Цагаандэлгэр	36,300	300	19,800	16,200	0.3	36.0	5,481,630	36.6	106,579	60,000	5,400,000	5,460,000	11,048,209
6	Өлзийт	65,300	300	33,000	32,000	0.3	65.0	9,835,980	65.6	191,027	60,000	9,750,000	9,810,000	19,837,007
7	Өндөршил	40,600	600	23,000	17,000	0.6	40.0	6,158,460	41.2	119,974	120,000	6,000,000	6,120,000	12,398,434
8	Гурвансайхан	58,100	600	32,500	25,000	0.6	57.5	8,786,085	58.7	170,934	120,000	8,625,000	8,745,000	17,702,019
9	Хулд	55,600	600	28,000	27,000	0.6	55.0	8,410,710	56.2	163,654	120,000	8,250,000	8,370,000	16,944,364
10	Луус	33,100	600	17,500	15,000	0.6	32.5	5,032,335	33.7	98,134	120,000	4,875,000	4,995,000	10,125,469
11	Сайхан-Овоо	49,770	600	23,515	25,655	0.6	49.2	7,535,336	50.4	146,677	120,000	7,375,500	7,495,500	15,177,513
12	Дэлгэрхангай	41,600	600	16,200	24,800	0.6	41.0	6,308,610	42.2	122,886	120,000	6,150,000	6,270,000	12,701,496
13	Эрдэнэдалай	118,200	1,200	65,000	52,000	1.2	117.0	17,872,470	119.4	347,693	240,000	17,550,000	17,790,000	36,010,163
14	Адаацаг	66,232	1,732	32,500	32,000	1.7	64.5	10,124,776	68.0	197,911	346,400	9,675,000	10,021,400	20,344,087
15	Сайнцагаан	82,900	900	42,300	39,700	0.9	82.0	12,540,990	83.8	244,026	180,000	12,300,000	12,480,000	25,265,016
Дүн		824,702	11,032	425,215	388,455	11.0	813.7	124,975,782	835.7	2,433,657	2,206,400	122,050,500	124,256,900	251,666,339